



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 488

Улаанбаатар
хот

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.5, 57.14 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралт, Нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалаас бусад төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг 2 дугаар хавсралт, Нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг 3 дугаар хавсралт, Цагдаа, дотоодын цэргээс бусад төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээг 4 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 5 дугаар хавсралт, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 6 дугаар хавсралт, төрийн улс төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээг 7 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 1 дэх заалтын “тус тус шинэчлэн баталж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэснийг “баталсугай.” гэж, “Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 375 дугаар тогтоолын 3 дахь заалт, мөн “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолын 4 дэх заалтын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолыг” гэснийг “төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 1 дэх заалтын “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, Цагдаа, дотоодын цэргээс бусад төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт,” гэснийг, мөн заалтын “Улс төрийн албан тушаал

эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг 11 дүгээр хавсралт," гэснийг, "Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай" Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолын 1 дэх заалтын ", Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, Төрийн захиргааны төв байгууллагын төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт" гэснийг, "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолын 1 дэх заалтын "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 2 дугаар хавсралт," гэснийг, мөн заалтын ", Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 7 дугаар хавсралт" гэснийг тус тус хассугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 2, 3, 11 дүгээр хавсралт, "Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай" Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 75 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт, "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолын 2, 7 дугаар хавсралт, "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

5.Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

6.Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Т.АЮУРСАЙХАН

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН
ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	1755052
T3-2	1611500
T3-3	1598762
T3-4	1566903
T3-5	1512024
T3-6	1452296
T3-7	1392567
T3-8	1283967
T3-9	1185243
T3-10	996753

---oOo---

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт


НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖДЭГ НУТГИЙН ӨӨРӨӨ
УДИРДАХ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛААС БУСАД ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	1232536
T3-2	1211164
T3-3	1151108
T3-4	1088657
T3-5	1045653
T3-6	1002648
T3-7	924456
T3-8	853375
T3-9	791532
T3-10	717662

---o0o---

Засгийн газрын 2022 оны 488-дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт



НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖДЭГ НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ
БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	1568850
T3-2	1447074
T3-3	1410705
T3-4	1354776
T3-5	1297336
T3-6	1227472
T3-7	1158512
T3-8	1068671
T3-9	988388
T3-10	857208

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт


ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГЭЭС БУСАД ТӨРИЙН ТУСГАЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТТ-1	1509000
ТТ-2	1452000
ТТ-3	1401000
ТТ-4	1250000
ТТ-5	1130000
ТТ-6	972300
ТТ-7	932389
ТТ-8	897200
ТТ-9	861887
ТТ-10	827968
ТТ-11	776260
ТТ-12	746085
ТТ-13	717345

---o0o---

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААС БУСАД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн доод хэмжээ
ТҮ-1	565277
ТҮ-2	593190
ТҮ-3	615152
ТҮ-4	638212
ТҮ-5	686638
ТҮ-6	766540
ТҮ-7	827799
ТҮ-8	861490
ТҮ-9	967621
ТҮ-10	998671
ТҮ-11	1007226
ТҮ-12	1075488

---o0o---

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД
БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн доод хэмжээ
ТҮ-1	589855
ТҮ-2	618980
ТҮ-3	641898
ТҮ-4	665959
ТҮ-5	716493
ТҮ-6	799869
ТҮ-7	863790
ТҮ-8	898946
ТҮ-9	1009691
ТҮ-10	1042091
ТҮ-11	1051018
ТҮ-12	1122249

---ооо---

Засгийн газрын 2022 оны 488 дугаар
тогтоолын 7 дугаар хавсралт



ТӨРИЙН УЛС ТӨРИЙН ЗАРИМ АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
Нийслэлийн Засаг даргын орлогч	1119472
Аймгийн Засаг даргын орлогч	1051067
Дүүргийн Засаг дарга	1111971
Дүүргийн Засаг даргын орлогч	950400
Сумын Засаг дарга	1052207
Сумын Засаг даргын орлогч	890013
Хорооны Засаг дарга	772398
Багийн Засаг дарга	697388

---o0o---